

Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн ажлын явцын танилцуулга

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5 тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 3 тогтоолоор нийслэл хотын хэмжээнд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэх 31 байршил, 88 хэсэгчилсэн талбайг баталсан. Энэ нь 23,096 нэгж талбар буюу 1615 га газрыг эзэлж байна. Тус байршлуудад батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 148,323 айлын орон сууц, 60 сургууль, 92 цэцэрлэг, 14 эмнэлгийг барьж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг нийт 34 компани төсөл хэрэгжүүлэгчийн төсөлд шалгарсан цаг хугацаа төсөл хэрэгжих талбайн онцлог зэргээс хамааран төслийн ажлын явц харилцан адилгүй байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 16 байршил 38 хэсэгчилсэн талбайд 34 төсөл хэрэгжүүлэгч батлагдсан барилгажилтын төсөл хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 3464 нэгж талбарын газар чөлөөлөлт хийгдсэн, 20,822 айлын орон сууц ашиглалтад оруулсан байна.

